

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,  
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2001 оны 04 дугаар  
сарын 11 ны өдөр

Дугаар 100/32

Улаанбаатар  
хот



Журам батлах тухай

Гэр бүлийн тухай Монгол Улсын хуулийн 58.7-д заасныг үндэслэн ТУШААХ  
НЬ:


1. " Гадаадын иргэнд Монгол Улсын харъяат хүүхдийг үрчлүүлэх  
журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод  
хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан, Нийгмийн хамгаалал,  
хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Жадамбаа нарт даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хууль зүйн сайд, Эрүүл мэнд,  
нийгмийн хамгааллын сайдын 1999 оны 237/А/287 дугаар тушаалыг хүчингүй  
болсонд тооцсугай.



Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн  
хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2001 оны  
100/32 дугаар тушаалын хавсралт



## ГАДААДЫН ИРГЭНД МОНГОЛ УЛСЫН ХАРЪЯАТ ХҮҮХДИЙГ ҮРЧЛҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Гадаадын иргэн Монгол Улсын харъяат хүүхдийг үрчлэн авахад Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай" Гаагийн Конвенци, "Гэр бүлийн тухай" Монгол Улсын хууль, энэ журам, холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө.
2. Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харъяат хүүхдийг үрчлэн авах тухай хүсэлтийг Монгол улсын Дипломат төлөөлөгчийн болон Консулын байгууллагаар уламжлан энэ журмын дагуу шийдвэрлэнэ.
3. Монгол улсын иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэн дагавар хүүхдээ үрчлэн авахад энэ журам үйлчлэхгүй.
4. Монгол Улсын харъяат хүүхдийг үрчлэн авсан гадаадын иргэнд эхний хүүхэд үрчлэн авснаас хойш нэг жилийн дотор тус улсын харъяат хүүхдийг дахин үрчлүүлэхгүй. Энэ нь ихэр хүүхэд эсхүл төрсөн ах, эгч, дүү нарыг үрчлэн авахад хамаарахгүй.
5. Гадаадын иргэн Монгол Улсын харъяат хүүхдийг үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны болон байнга оршин суугаа газрынхаа үрчлэлтийн асуудал эрхэлсэн байгууллагаар уламжлан Монгол Улсын Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.
6. Монгол Улсад 6 сараас доошгүй хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэн хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ энэ журмын 5-д заасан байгууллагаар дамжуулалгүйгээр Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.
7. Монгол Улсын харъяат хүүхдийг таваас доошгүй жил хамт амьдарсан гэр бүлд, эсхүл ганц бие гадаадын иргэн-эмэгтэйд үрчлүүлж болно.
8. 60-аас дээш насны гадаадын иргэн, эцэг эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, урьд үрчилж авсан хүүхдээ өөрийн буруугаас буцааж өгсөн, ашиг хонжоо олох зорилготой, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, сүрьеэ, ДОХ, сэтгэцийн өвчтэй, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг, эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн, хорих ял эдэлж байгаа болон ганц бие эрэгтэй гадаадын иргэнд Монгол Улсын харъяат хүүхдийг үрчлүүлэхгүй.

9. Долоо ба түүнээс дээш настай хүүхдийг үрчлүүлэхэд өөрийнх нь зөвшөөрлийг авч энэ тухай тэмдэглэл хөтөлнө.

### **Хоёр. Монгол улсын харъяат хүүхдийг үрчлүүлэх ерөнхий нөхцөл**

10. Үрчлэхийг хүсэгч гадаадын иргэн дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

а/ хүүхэд үрчлэн авах тухай /гэр бүлтэй бол хамтарч гаргасан/ өргөдөл, түүний албан ёсны орчуулга;

б/ иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиг болон гэр бүлтэй бол гэрлэлтийн гэрчилгээний хуулбар;

в/ өөрийн болон гэр бүлийн хоёр үеийн намтар, зураг, байнга оршин суугаа газрын болон санхүүгийн боломжийн тухай холбогдох байгууллагын тодорхойлолт;

г/ энэ журмын 8-д заасан харшлах нөхцөл байхгүй тухай цагдаа, эрүүл мэндийн болон холбогдох бусад байгууллагын тодорхойлолт;

д/ гадаадын харъяат хүүхэд үрчлэхийг болон түүнийг өөрийн улсад нэвтрэн орох, байнга оршин суухыг зөвшөөрсөн үрчлэгчийн харъяалах улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөл.

11. Энэ журмын 10-т заасан баримт бичгийг үрчлэгчийн харъяалах улсын холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтан гарын үсэг зурж, тамга \тэмдэг\ дарж баталгаажуулсан байна.

12. Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүүхэд үрчлэн авах тухай материалыг хүлээн авч баримт бичиг хангалттай бүрдсэн гэж үзвэл 30 хоногийн дотор үрчлэгдэх хүүхдийг судлан сонгож дор дурдсан материалыг бүрдүүлэн, үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнд холбогдох байгууллагаар дамжуулан хүргүүлнэ.

а/ төрсний гэрчилгээ;

б/ бүтэн өнчин, эцэг, эх нь тодорхойгүй хүүхэд үрчлэх бол асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эсвэл асрамжийн газрын зөвшөөрөл, түүнчлэн эцэг эх нь нас барсныг гэрчлэх баримт бичиг;

в/ хагас өнчин хүүхэд үрчлэх бол эцэг, эхийн хүүхдээ үрчлүүлэх тухай бичгээр гаргасан зөвшөөрөл;

г/ хүүхдийн эцэг эх сураггүй алга болсон буюу нас барсанд тооцогдсон, эсхүл эцэг эх байх эрхээ хасуулсан бол энэ тухай шүүхийн шийдвэр болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүүхэд үрчлүүлэх тухай бичгээр гаргасан зөвшөөрөл; / эцэг, эх байх эрхийг хассан тухай

шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дараа хүүхдийг үрчлүүлнэ/

д/ эцэг эх нь ахуй амьдралын гачигдлаас шалтгаалж хүүхдээ хэвийн өсгөх боломжгүй бол энэ тухай сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт, эцэг эхийн хүүхдээ үрчлүүлэх тухай бичгээр гаргасан зөвшөөрөл;

ж/ хүүхдийн эрүүл мэндийн талаархи эмнэлгийн байгууллагын дүгнэлт.

13. Энэ журмын 12-д заасан материалыг хүлээн авсан гадаадын иргэнээс хүүхдийг үрчилж авах тухай санал ирүүлсэн тохиолдолд Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага өөрийн санал дүгнэлтээ гаргаж холбогдох материалын хамт Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албанд хүргүүлнэ.

14. Монгол улсын харъяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх тухай Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх алба 30 хоногийн дотор үрчлэлтийн асуудлыг шийдвэрлэж, гаргасан шийдвэрийн талаар гадаад улсын иргэн болон эрх бүхий байгууллагад уламжилна.

15. Монгол улсын харъяат хүүхдийг үрчлэн авагч гадаадын иргэн дараахь үүрэг хүлээнэ:

а/ хүүхдийг хэвийн өсч бойжих, сурч боловсрох, эрхээ хамгаалуулах нөхцөлөөр хангах;

б/ хүүхдийн эх орон, шаардлагатай бол эцэг, эхийг мэдүүлэх;

в/ үрчлэн авсан хүүхдийн талаар 1 сартайгаас 3 нас хүртэл хагас жил тутам, 4-8 нас хүртэл жил тутам, 8-16 нас хүртэл хоёр жил тутам Монгол улсын Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албанд мэдээлэл ирүүлэх;

г/ шаардлагатай тохиолдолд Монгол улсын эрх бүхий байгууллагаас тухайн хүүхдийн аж байдалтай танилцах, түүнтэй ярилцах боломжоор хангах.

### **Гурав. Хүүхэд үрчилснийг бүртгэх**

16. Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албаны даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв үрчлэгдэх хүүхдэд төрсний гэрчилгээ, хүүхдээ үрчлүүлж байгаа эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд хүүхэд үрчлүүлсний гэрчилгээ, хүүхэд үрчлэн авсан гадаадын иргэнд хүүхдийг үрчлэн авсны гэрчилгээ олгож үрчлэлтийг бүртгэнэ.

17. Хүүхэд үрчлэн авсныг бүртгэхэд хүүхэд үрчлэн авч байгаа эцэг эх, эсхүл тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгч, үрчлүүлж байгаа эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл тэдгээрийн төлөөлөгчийг байлцуулна.

### **Дөрөв. Бусад**

18. Үрчлэгч нь эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэй хэрцгий харьцсан, хуурамч баримт бичиг бүрдүүлэн үрчлэх шийдвэр гаргуулсан тохиолдолд үрчлэлтийг хүчингүй болгох тухай асуудлыг эрх бүхий байгууллага\шүүх\-д тавьж шийдвэрлүүлнэ.

19. Үрчлэлтийг хүчингүй болгосноос гарах зардлыг үрчлэн авагч бүрэн хариуцна.

20. Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх алба нь үрчлэгдсэн хүүхдийн талаарх мэдээллийг үрчлэгчийн харьяалах улсад суугаа Монгол улсын Дипломат төлөөлөгчийн болон Консулын байгууллагад албан ёсоор мэдэгдэнэ.

21. Үрчлэлтийн асуудалд олон нийтээс тавих хяналтыг Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын итгэмжлэгдсэн этгээд хэрэгжүүлж болно.